



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

ОРОЛЦООНД СУУРИЛСАН ЖЕНДЭРИЙН АУДИТ ХИЙХ АРГАЧЛАЛ

**ОРОЛЦООНД СУУРИЛСАН
ЖЕНДЭРИЙН АУДИТ ХИЙХ
АРГАЧЛАЛ**

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны даалгавраар Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн хэрэгжүүлж буй “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” (ТСТМБС) төслийн дэмжлэгтэйгээр энэхүү аргачлалыг хэвлэв.

Боловсруулсан:

С.Түмэндэлгэр Доктор, дэд профессор

Ц.Одгэрэл Докторант

Т.Бүрэнжаргал Доктор, профессор

Б.Доржпагма Магистр

Хянасан:

Б.Болор Магистр

Хаяг: “Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт” төсөл

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)

Найман зовхис барилгын IV давхар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг,

Улаанбаатар 14251, Монгол улс

Утас: 976-7000 5340

E-mail: beate.dippmar@giz.de

Фэйсбүүк хаяг:

Хэвлэлийн формат: А5 (210x297)

Хэвлэсэн газар: “Сэлэнгэпресс” ХХК-ийн хэвлэх үйлдвэр.

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн тоо: 200

Дизайнер: Б.Одонгуа

ISBN

Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.

УДИРТГАЛ

Товч танилцуулга	6
Аргачлалын зорилго, зорилтууд	6
Аргачлалыг хэн ашиглах вэ?	6
Аргачлалыг хэрхэн ашиглах вэ?	6

НЭГ: ОЙЛГОЛТОО НЭГТГЭЦГЭЭ 8

1.1	Жендэрийн үндсэн ойлголт	8
1.2	Жендэрийн аудитын зорилго, зорилт	9
1.3	ОСЖА-ын дүн шинжилгээний таван хүрээ	9
1.4	ОСЖА-ын үе шат	10

ХОЁР. БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ 11

Алхам 2.1	ОСЖА хийх чиглүүлэгчдийн багийн зохион байгуулалтыг хангах	11
Алхам 2.2	Жендэрийн аудитын календарчилсан төлөвлөгөө боловсруулах	12
Алхам 2.3	Байгууллагын удирдлага, нэгж, албадын удирдах ажилтнуудад ОСЖА хийх танилцуулга, зөвлөлдөх уулзалт хийх	12

ГУРАВ. ОРОЛЦООНД СУУРИЛСАН ЖЕНДЭРИЙН АУДИТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ 13

Аргачлал 3.1	Баримт бичгийн судалгаа хийх	13
Аргачлал 3.2	Стандартчилсан ярилцлага хийх	14

ДӨРӨВ. БАГШ, АЖИЛТАН БОЛОН ОЮУТАН СУРАЛЦАГЧДААС АСУУЛГЫН АРГААР МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ НЬ 15

ТАВ. ДҮГНЭХ, ТАЙЛАГНАХ НЬ 16

ХАВСРАЛТУУД 18

Хавсралт 1.1.	Жендэр аудитын зорилго, зорилтууд	18
Хавсралт 2.1	ОСЖА-ын календарчилсан төлөвлөгөө, сар, өдрөөр	19
Хавсралт 3.1.1	Баримт бичгийн жагсаалт	20
Хавсралт 3.1.2	Баримт бичгийн судалгааны дүн шинжилгээний нэгдсэн хүснэгт	21
Хавсралт 3.1.3	Баримт бичгийн судалгааны дүгнэлт, зөвлөмжийн хүснэгт	23
Хавсралт 3.2.1	Стандартчилсан ярилцлагын удирдамж	23
Хавсралт 3.2.2	Стандартчилсан ярилцлагын үр дүнгийн нэгтгэл	26
Хавсралт 4.1.1	Түүврийн төлөвлөлт боловсруулах удирдамж	27
Хавсралт 4.1.2	Багш, ажилтны асуулга	29
Хавсралт 4.1.3	Оюутан суралцагчийн асуулга	32
Хавсралт 5.1	ОСЖА-ын тайлангийн жишиг бүтэц	34
Хавсралт 5.2	Ажилтнуудын саналыг нэгтгэх хүснэгт	36
Хавсралт 5.3	Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний маягт	37
Хавсралт 5.4	Хяналт шинжилгээ (мониторинг) хийхэд ашиглах маягт	38

ААБД	Ажлын байрны бэлгийн дарамт
ЖҮАТ	Жендэрийн үйл ажиллагааы төлөвлөгөө
ЖЭТБ	Жендэрийн эрх тэгш байдал
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
МБТБСБ	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага
ОСЖА	Оролцоонд суурилсан жендэрийн аудит
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ХШҮ	Хяналт шинжилгээ, үнэлгээ

Товч танилцуулга

Оролцоонд суурилсан жендэрийн аудит (ОСЖА) нь байгууллагын жендэрийн тэгш байдлын ахиц дэвшлийг үнэлж, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд нэгтгэх, жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцыг дэмжихэд чиглэдэг (ILO, 2007). ОСЖА нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг байгууллагын бүх үйл ажиллагаанд нэвтрүүлэх үр дүнтэй, бүтээмжтэй арга замыг байгууллагын ажилтнуудын оролцоотойгоор тодруулж өгдөг чанарын аудитын нэгэн төрөл юм. ОСЖА нь байгууллагын хувьд суралцах, чадавхаа бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдгаараа онцлогтой.

Ажиллах, суралцах газар бол хүний хамгийн их цагаа зарцуулдаг нийгмийн орчны нэг. Ажил руугаа ч яардаг, гэр рүүгээ ч яардаг хүнийг аз жаргалтайд тооцно гэсэн үг бий. Ажлын болон сургалтын орчин руугаа сэтгэл татагдаж яарах нь тэгш байдал, тэгш боломж олгогдож, ямар нэгэн шинжээр ялгаварлагдсан гэсэн мэдрэмж төрөхгүй байхаас ихээхэн хамаардаг. Жендэр нь хувь хүний өөрийгөө мэдрэх, хүлээн авах, илэрхийлэх, ямар үйлдлийг хийж болох, болохгүйг тодорхойлж, болох бол хэрхэн хийхийг чиглүүлэх замаар бидний өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд нөлөөлж байдаг. Эрх мэдлээр доогуур бүлгийнхэнд дорд үзэгдэх зэргээр ялгаварлагдаж, тэгш бус боломж бүхий байдлыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй нөхцөлд оруулж шахаж байдаг. ОСЖА-ыг хэрэглэснээр байгууллагын бүтэц, соёл, харилцаан дахь жендэрийн ялгаварлал, тэгш бус байдлын асуудлыг олж харах, улмаар өөрчлөхөөр санал нэгдэхэд хүргэдэг. Иймээс байгууллага, хамт олон дахь үл анзаардаг, байх л ёстой гэсэн бугшсан асуудлыг ил гаргаж, улмаар шийдвэрлэх арга замуудыг олж харахад туслах юм.

Энэхүү ОСЖА-ын аргачлал (toolkit)-ыг боловсруулахдаа ОУХБ-аас эрхлэн гаргасан гарын авлагад тулгуурласны зэрэгцээ бид 2017 оноос салбар, байгууллагын түвшинд жендэрийн тэгш байдлын нөхцөл байдлыг тодруулах зорилго бүхий үнэлгээ, судалгаанд ашиглаж ирсэн аргуудыг ашиглав. Тус аргачлал (toolkit) нь байгууллага, түүний нэгжид жендэрийн аудит хийхэд ашиглах удирдамж, практик зааварчилгаа болно.

ОСЖА гүйцэтгэх баг тус аргачлалын үе шат, алхмуудыг даган, хавсралт дахь хэрэглэгдэхүүнийг шууд ашиглахуйц, ойлгомжтой байлгахаар зорьж ажиллав. ОСЖА нь төлөвлөх, мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийх, тайлагнах, жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд мониторинг хийх гэсэн орчлоор явагдана.

Аргачлалын зорилго, зорилтууд

Аргачлал нь МБТБСБ-ын удирдлага, ажилтнуудад оролцоонд суурилсан жендэрийн аудитыг хэрэгжүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, өөрчлөлтийн үйл явцыг эхлүүлэхэд туслах зорилготой.

Энэхүү аргачлалын зорилт нь:

- * Оролцоонд суурилсан жендэрийн аудитын зорилго, үйл явцын алхам бүрийн талаар мэдлэгтэй болоход тусална.
- * Алхам бүрээр ОСЖА-ыг хөтлөн явуулахад удирдан чиглүүлнэ.
- * Шаардлагатай хэрэглэгдэхүүн, нөөц, мэдээллээр хангана.

Аргачлалыг хэн ашиглах вэ?

Аргачлалыг МБТБСБ-ын удирдлага, багш, ажилтнууд ашиглана. Тухайн байгууллагын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, жендэрийн багийн гишүүд эсвэл МБТБСБ-ын удирдах албан тушаалтан, захиргаа хүний нөөц, судалгаа, ХШҮ, санхүү хариуцсан ажилтны төлөөллөөс бүрдсэн чиглүүлэгчдийн баг ОСЖА-ыг хэрэгжүүлнэ.

Аргачлалыг хэрхэн ашиглах вэ?

Тус аргачлал нь оролцооны аргаар жендэрийн аудитыг хийх үйл явцад алхам алхмаар чиглүүлсэн удирдамж юм. Тийм учраас чиглүүлэгчид ОСЖА-ын үе шат бүрт ашиглах хүснэгт,

загвар, жишиг маягтыг багтаасан.

Нэгдүгээр хэсэг жендэрийн үндсэн ойлголт, байгууллагад жендэрийн эрх тэгш байдлыг хангахын ач холбогдол, ОСЖА-ын зорилго, зорилтууд, үе шатууд гэсэн хэсгээс бүрдэнэ.

Хоёрдугаар хэсгээс ОСЖА-ыг хийх багийн зохион байгуулалт, багийн гишүүдийн үүрэг оролцоо, бэлтгэл үйл ажиллагаа, багийн уулзалт, ОСЖА-ын календарчилсан төлөвлөгөөг хийх зааварчилгааны тухай уншина.

Гуравдугаар хэсгээс ОСЖА-ын явцад баримт бичгийн дүн шинжилгээ, стандартчилсан ярилцлага хийх удирдамжийн тухай судална.

Дөрөвдүгээр хэсгээс МБТБСБ-ын ажилтан, оюутан суралцагчдаас асуулгын аргаар хэрхэн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх талаар удирдамж, заавартай танилцана.

Тавдугаар хэсэгт ОСЖА-ын тайлан боловсруулах, ОСЖА-ын үр дүнг танилцуулах, ОСЖА-ын үр дүнд тулгуурлан жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах алхамчилсан зааварчилгааг өгсөн.

Хавсралт хэсгээс ОСЖА-ын үе шат бүрийн хэрэглэгдэхүүнийг ашиглаарай.

НЭГ: ОЙЛГОЛТОО НЭГТГЭЦГЭЭ

1.1 Жендэрийн үндсэн ойлголт

МБТБСБ-д жендэрийн аудит хийх чиглүүлэгчдийн багийн гишүүд жендэрийн суурь ойлголтуудаа сайтар мэдэх хэрэгтэй юм. Жендэрийн аудитын чиглүүлэгчдийн баг 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг судалсан байна. Чиглүүлэгчдийн багийн бүх гишүүн жендэрээр мэргэшсэн байх шаардлагагүй ч багийн бүрэлдэхүүнд заавал жендэрийн мэргэжилтэн байна. Жендэрийн үндсэн ойлголтыг чиглүүлэгчдийн багийн гишүүн бүр танилцаж эзэмшсэн байвал зохино.

Хүснэгт 1.1 Жендэрийн болон оролцоонд суурилсан аудитын үндсэн ойлголтууд

Үндсэн ойлголтууд	Тайлбар
Хүйс (Sex)	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн ялгаатай байдал, хэв шинжийг илэрхийлэх бөгөөд эрэгтэй хүн, эмэгтэй хүн гэж ялган ангилахыг хэлнэ. Хүйс бол нийгмээс хамаарч өөрчлөгдөхгүй, төрөлхийн буюу заяагдмал шинжийг агуулдаг.
Жендэр (Gender)	Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг (ЖЭТБХТХ, 2011) хэлнэ.
Жендэрийн үүрэг (Gender roles)	Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хүлээж буй ялгаатай үүрэг, хариуцлага нь тухайн нийгмээр тодорхойлогддог ч цаг хугацааны хувьд болон нийгэм, хөгжлөө дагаж өөрчлөгддөг.
Жендэрийн тэгш эрх (Gender equity)	Эрэгтэй, эмэгтэй хоёуланд нь ялгаварлалгүй байх үйл явцыг хэлдэг. Жендэрийн эрх тэгш байдлыг тогтооход чиглэсэн аливаа төрлийн арга хэмжээ, стратеги.
Жендэрийн тэгш байдал (Gender equality)	Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ.
Жендэрийн хэвшмэл үзэл (Gender stereotype)	Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг хэлнэ.
Жендэрийн ялгаварлан гадуурхалт (Gender discrimination).	Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар тэгш бус нөхцөлд оруулах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхгүйг (ЖЭТБХТХ, 2011) хэлнэ.
Бэлгийн дарамт (Sexual harassment)	Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхгүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг хэлнэ.
Жендэрт суурилсан хүчирхийлэл (Gender based violence)	Жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.
Жендэрийн мэдрэмжтэй хяналт шинжилгээ, үнэлгээ (Gender sensitive monitoring&evaluation)	Аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны орц, хэрэгжилтийг эрэгтэй, эмэгтэйчүүдийн оролцоотойгоор тухайн бодлогын үр дүн, үр нөлөө (зерэг, сөрөг) тэдэнд ялгаатай эсэх талаар шалгуур үзүүлэлт тогтоон, мэдээлэл цуглуулах, хяналт үнэлгээ хийх үйл явцыг хэлнэ.
Хүйсээр ангилсан мэдээлэл (Sex disaggregated data)	Эрэгтэй болон эмэгтэй гэсэн хувьсагчаар ангилагдсан мэдээлэл.
Жендэрийн мэдрэмжтэй төсөв (Gender responsive budget)	Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээг харгалзан төлөвлөж, төсөвлөх, хуваарилах, зарцуулах, хянах, тайлагнахыг ойлгоно.

Оролцоонд суурилсан жендэр аудит (Participatory gender audit)	Жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт шинжилгээ ба үнэлгээнд үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд байгууллагын болон хувь хүний чадавх нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн оролцоонд суурилсан арга хэрэгсэл, үйл явц юм.
--	---

Дараах гарын авлагыг ашиглан, багийн гишүүдийн жендэрийн болон оролцоонд суурилсан жендэрийн аудитын мэдлэг ойлголтыг сайжруулах сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж болно.

1. ЖҮХ (2020) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт, төсөвлөлт. Гарын авлага <https://www.ncge.gov.mn/publications/36>
2. ЖҮХ (2020) Жендэр ба бодлого төлөвлөлт. Гарын авлага. <https://www.ncge.gov.mn/publications/48>
3. ILO (2007) Manual for gender audit facilitators: ILO Participatory gender audit methodology. Geneva, International Labour Office. https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/--dcomm/---publ/documents/publication/wcms_093425.pdf

1.2 Жендэрийн аудитын зорилго, зорилт

Жендэрийн аудитын зорилго нь МБТБСБ -д ОУХБ-ын ОСЖА-ын аргачлалаар жендэрийн нөхцөл байдлыг тодорхойлох, байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлогын жендэрийн нөлөөллийг үнэлж, байгууллагын хэмжээнд баримтлах жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилтууд:

1. Ажлын нэгж дэх жендэрийн асуудлууд, жендэрийн асуудлаар мэргэшсэн байдал, мэдлэг чадвар, туршлага, чадавх бүрдүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох
2. Ажлын нэгжийн зорилтууд, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн үе шатууд дахь жендэрийн агуулга тусгасан эсэхэд дүгнэлт өгөх,
3. Ажлын нэгж дэх мэдээллийн менежмент, ХШҮ-ний тогтолцоо нь нээлттэй, ил тод, ажилтан бүрийн оролцоог хангаж буй эсэхийг тодорхойлох,
4. Шийдвэр гаргах үйл явц, боловсон хүчний бүрэлдэхүүн, хүний нөөц болон байгууллагын соёлд оролцогч талуудын жендэрийн мэдлэг, хандлагыг илрүүлэх,
5. Байгууллагын жендэрийн тэгш байдлыг хангах ажлын ололт амжилтаа үнэлж буй байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх.

ОСЖА-ын зорилго, зорилтыг боловсруулахдаа Хавсралт 1.1-ийг ашиглаарай.

1.3 ОСЖА-ын дүн шинжилгээний таван хүрээ

Дүн шинжилгээний гол хүрээг сонгож тогтоох: жендэрийн аудитын үр дүнг тодорхойлоход дараах дүн шинжилгээний хүрээг ашиглана:

№	Дүн шинжилгээний 5 гол хүрээ	Тайлбар
1	· Байгууллага, нэгж дэх жендэрийн асуудлууд, уг асуудлаар мэргэшсэн байдал, мэдлэг чадвар, туршлага, чадавх бүрдүүлэлт	Ажлын нэгжийн орчин, нөхцөл байдал болон техник ажлын хүрээн дэх жендэрийн асуудалд хандаж буй байдал, жендэрийн сэдвээр өрнөж буй мэтгэлцээн, санаачилгууд, жендэрийн асуудлаар мэргэшсэн байдал, мэдлэг чадвар, туршлага, чадавх бэхжүүлэх хүчин чармайлтад үнэлэлт өгнө.
2	· Байгууллага, нэгжийн зорилтууд, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийн үе шатууд дахь жендэрийн агуулга, түншлэгч байгууллагуудыг сонгосон байдал	Ажлын нэгжийн стратегийн зорилтууд, бодлого хөтөлбөр, төсөвт жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгасан байдал, хөтөлбөрүүд, техникийн хамтын ажиллагааны хэрэгжилтэд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгасан байдал, жендэрийн тэгш байдлын талаарх хариуцлагын тогтолцоо болон ХШҮ-ний арга хэрэгсэл, ажлын түншлэгчдээ сонгосон байдалд үнэлэлт өгнө.

3	· Байгууллага, нэгж дэх мэдлэг мэдээллийн менежмент, бүтээгдэхүүн болон нийгмийн дүр төрхөд жендэрийн тэгш байдлын бодлогын тусгал	Жендэрийн асуудлаарх мэдлэг мэдээллийн менежмент, нэгжийн бүтээгдэхүүн болон нийгэм дэх дүр төрхөд жендэрийн тэгш байдлын бодлогын нөлөөлөлд үнэлэлт өгнө.
4	· Шийдвэр гаргах үйл явц, боловсон хүчний бүрэлдэхүүн, хүний нөөц болон байгууллагын соёл	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг шийдвэр гаргах үйл явцад нэгтгэсэн байдал, боловсон хүчний бүрэлдэхүүн, хүний нөөцийн хүйсийн тэнцвэрт анхаарч буй байдал, жендэрийн мэдрэмжтэй бодлого, байгууллагын соёл ба түүний жендэрийн асуудалд нөлөөлөх байдалд үнэлэлт өгнө.
5	· Байгууллага, нэгжийн жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны ололт амжилтыг үнэлж буй байдал	Жендэрийн тэгш байдал хэрхэн хангагдаж байгаа талаарх ойлголт, санаа бодолд үнэлэлт өгнө.

Дүн шинжилгээний 5 хүрээгээр аудит хийх шаардлагагүй тохиолдолд тохиромжтой хүрээг ашиглаж болно.

1.4 ОСЖА-ын үе шат





Алхам 2.1 ОСЖА хийх чиглүүлэгчдийн багийн зохион байгуулалтыг хангах

Зохицуулагчийг сонгох

ОСЖА-ыг МБТБСБ-ын захиргаа удирдлага, хүний нөөц, ХШҮ, багш, оюутан, түншлэл хамтын ажиллагаа хариуцсан нэгж албад болон хүний нөөцийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан зэрэг ялгаатай оролцогч талуудын оролцоотой зөвшилцөн, жендэрийн аудитын багийн зохицуулагчийг сонгоно. ОСЖА-ыг хариуцах зохицуулагчийг МБТБСБ-ын захирлын тушаалаар томилж ажиллуулна.

Зохицуулагч бол ОСЖА-ыг амжилттай хэрэгжүүлэхэд түлхүүр үүрэгтэй оролцогч юм.

* ОСЖА-ын бэлтгэл үе шатанд зохицуулагч дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Зохицуулагч нь;

- * МБТБСБ-ын удирдлага болон захиргаа хүний нөөцийн мэргэжилтнүүдтэй уулзаж ОСЖА хийх төлөвлөгөөг танилцуулж, зөвшилцөх,
- * ОСЖА-ын чиглүүлэгчдийн багийг бүрдүүлж, удирдлага, зохицуулалтаар хангах,
- * МБТБСБ-ын нэгж, албад ба чиглүүлэгчдийн дунд холбогчийн үүрэг гүйцэтгэх
- * ОСЖА-ыг төлөвлөх, бэлтгэхэд туслах
- * Чиглүүлэгчдийн багийн гишүүдийг сонгох
- * Баримт бичгийн судалгаанд шаардлагатай бичиг баримт, материалуудыг цуглуулж, чиглүүлэгчдийн багт хүргэх
- * МБТБСБ-ын ажилтнуудтай хийх стандартчилсан ярилцлагыг товлох
- * Мэдээлэл цуглуулалт болон түншлэгч талуудтай хийх уулзалтын зохион байгуулалтыг хариуцах
- * Семинарыг товлож, ложистикийн ажлыг хариуцах

Чиглүүлэгчдийн баг бүрдүүлэх

Чиглүүлэгчдийн баг 4 хүний бүрэлдэхүүнтэй байх ба баримт бичгийн судалгаа, ОСЖА-ын бэлтгэл уулзалтууд, ярилцлага, хэлэлцүүлгүүд хийх, асуулгаар мэдээлэл цуглуулах, тайлан боловсруулж, зөвлөмжийг удирдлага болон ажилтнуудад хүргэнэ.

Чиглүүлэгчдийн багийг бүрдүүлэхдээ эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд болон нийгмийн ялгаатай бүлгүүдэд тэгш боломж олгох зарчмыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй эсэхийг шалгуур болгож сонгоно. Гэхдээ багт жендэрийн чиглэлээр сургалтад хамрагдаж, бэлтгэгдсэн нэг мэргэжилтэн заавал байх шаардлагатай. Чиглүүлэгчдийн багийг бүрдүүлэхэд дараах ур чадвар, шаардлагыг харгалзах ёстой юм. Үүнд:

Чиглүүлэгчид тавигдах ур чадвар	Чиглүүлэгчийн багийн бүрэлдэхүүнд тавигдах шаардлага	Чиглүүлэгчийн анхаарах зүйл
<ul style="list-style-type: none"> - Жендэрийн талаар мэдлэгтэй - Судалгаа, шинжилгээний ур чадвартай 	<ul style="list-style-type: none"> - 21-30 хоногийн турш ажиллах боломжтой байх - Тайлан бичих чадвартай чиглүүлэгчийг багийн ахлагчаар томилох - Багт хүйсийн тэнцвэр хангасан байх (4 хүнтэй багт хамгийн багадаа 1 эрэгтэй) - Жендэрийн мэргэжилтэнтэй байх 	<ul style="list-style-type: none"> - Багаар ажиллах - Цаг баримтлан үр дүнтэй ажиллах - Цагдаа мэт байхаас зайлсхийх - Хувийн ашиг сонирхлоос ангид байх - Өөрчлөлтөд чиглүүлэх, туршлагаа дүгнэх, санаачилга гаргах, суралцах үйл явцыг дэмжих - Таатай уур амьсгалыг бүрдүүлэх - Хувь хүний нууцыг хадгалах

- * Чиглүүлэгчдийн багийн гишүүдийн бүрэлдэхүүн, ажил үүргийг хуваарилж, МБТБСБ-ын захирлын тушаалаар албажуулна.
- * ОСЖА эхлэхийн өмнө чиглүүлэгчийн багийн гишүүд баримт бичигт шинжилгээ хийх, стандартчилсан ярилцлага хийх, тэмдэглэл хөтлөх, тайлан бичих зэрэг туршлагаа хуваалцаж, ажил үүргийг оновчтой хуваарилна. Чиглүүлэгчдийн багийн 1 гишүүн нь баримт бичгийн судалгааг хийх, 2 гишүүн нь стандартчилсан асуулга судалгааг хийх, бүх гишүүн боловсуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ. Зохицуулагч ОСЖА-ын менежментийн үйл ажиллагааг хариуцна.
- * ОСЖА-ын эхнээс чиглүүлэгчдийн багийн гишүүд өдөр бүр ажлын дараа ОСЖА-ын явцын талаар тогтмол хэлэлцэж байх нэмж тодруулах, ойлголтоо бататгах, олж мэдсэнээ хуваалцаж, тухайн өдрийн амжилт, анхаарах зүйлсийн талаар дүгнэлт хийнэ.

Алхам 2.2 Жендэрийн аудитын календарчилсан төлөвлөгөө боловсруулах

Чиглүүлэгч багийн гишүүд ОСЖА-ын календарчилсан төлөвлөгөөг боловсруулж, МБТБСБ-ын нэгж, албадтай зөвшилцөж эцэслэнэ. Календарчилсан төлөвлөгөөг боловсруулахдаа ОСЖА-ыг зохион байгуулах байршил, баримт бичгийн шинжилгээ, стандартчилсан ярилцлага, асуулга, хэлэлцүүлгийн товыг МБТБСБ-тай хамтран төлөвлөж, гарч болзошгүй эрсдэл, бэрхшээлийг урьдчилан харж тооцох хэрэгтэй. ОСЖА-ын нийт үргэлжлэх хугацааг 21-30 хоног байхаар календарчилсан төлөвлөгөөг боловсруулна.

ОСЖА-ын календарчилсан төлөвлөгөөг **Хавсралт 2.1**-ийг ашиглан төлөвлөнө.

Алхам 2.3 Байгууллагын удирдлага, нэгж, албадын удирдах ажилтнуудад ОСЖА хийх танилцуулга, зөвлөлдөх уулзалт

Чиглүүлэгчдийн багийн зохицуулагч нь МБТБСБ-ын удирдлага болон ажилтнуудтай хийх уулзалтыг товлож, чиглүүлэгчдийн багийн гишүүдийн хамтаар жендэрийн аудитын танилцуулгыг хийнэ.

- * Юуны түрүүнд сургуулийн захиралтай уулзаж, ОСЖА-ын зорилго, ажил үүрэг, үйл ажиллагааны төлөвлөлтийг танилцуулна.
- * Үүний дараагаар нь МБТБСБ-ийн нэгж, албадын удирдах ажилтантай уулзаж, чиглүүлэгчдийн багийн гишүүд болон ОСЖА-ын зорилгыг танилцуулна.

ГУРАВ. ОРОЛЦООНД СУУРИЛСАН ЖЕНДЭРИЙН АУДИТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Аргачлал 3.1 Баримт бичгийн судалгаа хийх нь

Чиглүүлэгчдийн багийн гишүүд дүн шинжилгээ хийх баримт бичгүүдийг зохицуулагчаас хүлээн авч, дүн шинжилгээг эхлүүлнэ. Жендэрийн аудитын явцад баримт бичгүүдийг нэмэлтээр судлах шаардлага гардгийг анхаарна уу.

Баримт бичгийг сонгохдоо дараах нөхцөлийг харгалзаарай.

- * ОСЖА хийгдэх үед хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдийг хамарна.
- * Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй мөрдөгдөх үндэсний хэмжээний эрх зүйн баримт бичиг болон стандартуудыг судална.

Багийн гишүүдийн ажлын ачааллыг харгалзан дунджаар 8-10 баримт бичгийг судлахаар хуваарилна. Багийн зохицуулагч баримтын судалгааны үр дүнг нэгтгэнэ.

Байгууллагын баримт бичгийг доорх таван хэсэгт хуваан шинжилнэ.



Үйл ажиллагаа:

Алхам 1. Баримт бичгийн судалгаанд МБТБСБ-аас зайлшгүй хамруулах шаардлагатай, нийтлэг боловсруулан мөрдөж буй баримт бичгийн жагсаалтыг бэлтгэнэ. Үүнд Хавсралт 3.1.1-ийг ашиглана уу.

Алхам 2. Бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийхдээ дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:

- * Жендэрийн тэгш байдал тогтоохыг зорилго болгосон эсэх
- * Жендэрийн тэгш байдал тогтоохыг зорихдоо хүйсээр ангилсан тоо, баримтууд, дүн шинжилгээ ашигласан эсэх:
- * Тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн жендэрийн зарим тусгайлсан ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн эсэх (хэд хэдэн хариулт гарч болно):

Алхам 3. Эрх зүйн баримт бичиг дүн шинжилгээ хийхдээ дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:

- * Ажил горилогч, ажилтнуудын жендэрийн тэгш эрхийг хангасан зохицуулалт бий эсэх
- * Жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглосон эсэх
- * Ажилтны ажил-гэрийн үүргийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн зохицуулалт бий эсэх
- * Ажилтан, оюутан суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзах тухай зохицуулалт бий эсэх
- * Жендэрийн ялгаварлан гадуурхалт, ААБД-д өртсөн тохиолдолд гомдол гаргах механизмыг зохицуулсан эсэх
- * Гомдол барагдуулах хараат бус хүйсийн тэнцвэртэй зөвлөл, комисс ажиллах боломжийг бүрдүүлсэн эсэх

* Гомдол гаргагчийн хувийн нууцлалыг хадгалах, хариуцлагыг механизмыг зохицуулсан эсэх зэрэг болно.

Алхам 4. Цахим баримт бичигт шинжилгээ хийх.

Цахим хэлбэрийн баримт бичгүүдийг шинжлэхдээ Word эсвэл PDF программын “Find” функцийг ашиглан “жендэр, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, эмэгтэй, эрэгтэй, ялгаварлан гадуурхалт, тэгш байдал, тэгш эрх, хүйсийн тэнцвэр” гэсэн түлхүүр үгсээр жендэрийн агуулга тусгагдсан эсэхийг тодорхойлсны дараа агуулгын шинжилгээ хийнэ.

Алхам 5. Нэгдсэн дүгнэлт зөвлөмж боловсруулна. Хавсралт 3.1.2-ыг ашиглан эхлээд нэгтгэн шинжлээд, дараагаар нь Хавсралт 3.1.3-ыг ашиглан таван бичиг баримтын төрлөөр дүгнэлт, зөвлөмж гаргана.

Чиглүүлэгчид хавсралт дахь аргачлалын дагуу баримт бичгийн судалгааг гүйцэтгэнэ. Баримт бичгийн судалгааг хийх явцад шалгуур үзүүлэлтийг өөрчлөн сайжруулж, хялбаршуулж болно.

Аудитын тайланд баримт бичгийн судалгааны үр дүн (асуудлууд, ахиц дэвшилт)-г нэгтгэн оруулна. Шаардлагатай хэсэгт нотолгоо болгон баримт бичгээс эшлэн оруулах хэрэгтэй. Чиглүүлэгчдийн багийн гишүүн бүр судалсан баримтуудад үндэслэн тайлан ноороглож, багийн ахлагч нэгтгэн тайланд оруулна.

Аргачлал 3.2 Стандартчилсан ярилцлага хийх нь

Стандартчилсан ярилцлагын бэлтгэл хангах

Чиглүүлэгчдийн багийн хоёр судлаач МБТБСБ-ын ажилтнуудтай стандартчилсан ярилцлага хийх ба 45-90 минут үргэлжилнэ. Чиглүүлэгчдийн багийн гишүүн нь сургуулийн удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, санхүү, нягтлан бодох, олон нийттэй харилцах, мэдээллийн ажилтантай ээлжлэн ярилцахаар, цагийг хуваарилна.

Ярилцлагын өмнө дараах бэлтгэлийг хангасан байна.

- * Ярилцлага хийх орчин (офис, уулзалтын өрөөг бэлдэж, хүмүүс саад болох, утас дуугарах, давхацсан уулзалт төлөвлөгдөх зэргээс сэргийлэн)- бүрдүүлэхэд бэлдэнэ.
- * Баримт бичгийн судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулсан асуултуудыг дахин хянаж, ярилцах ажилтны албан тушаал, байр суурьтай нийцтэй эсэхийг нягтална.
- * **Хавсралт 3.2.1** дэх хэрэглэгдэхүүнийг ашиглан ярилцлага явуулна.

Стандартчилсан ярилцлагын мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Стандартчилсан ярилцлагын үр дүнг дүн шинжилгээний 5 гол хүрээгээр хуулбарлан буулгаж, гарсан дэвшил хийгээд өөрчлөлт хийх шаардлагатай асуудлыг тодруулна. Ярилцлагын тэмдэглэлээс ач холбогдолтой яриаг тайланд эшлэн оруулна.

ДӨРӨВ. БАГШ, АЖИЛТАН БОЛОН ОЮУТАН СУРАЛЦАГЧДААС АСУУЛГЫН АРГААР МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ НЬ

Зорилго:

Байгууллага дахь жендэрийн тэгш байдлын ерөнхий төлөв байдлыг тодруулах, ажилтан, оюутан суралцагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлага, өөрчлөлтийн хэрэгцээг тодорхойлно.

Анхаарах зүйлс:

- * Урьдчилж асуулгын хуудсыг оролцогчдын тоогоор хувилж бэлтгэсэн байна. Эсвэл google-form ашиглан цахим хэлбэрээр бэлтгэж болно.
- * Асуулгыг авахаасаа өмнө баримт бичгийн шинжилгээ, стандартчилсан ярилцлагаар байгууллагын жендэрийн нөхцөл байдлыг тодруулсан байна.
- * Бэлтгэсэн асуулгын хуудсыг МБТБСБ-ын онцлогтой уялдуулан засаж болно.
- * Ажилтнуудаар бөглүүлж, үр дүнг төгсгөлийн уулзалтад танилцуулна. Хариултын хувийн жинг эрэгтэй, эмэгтэй оролцогчдоор ангилан хүснэгт, график болон бусад дүрслэлээр харуулна.

Үйл ажиллагаа:

Алхам 1. Асуулгыг ажилтан, оюутан суралцагчдаар бөглүүлнэ. Цахим хэлбэрт шилжүүлэн бөглүүлж болно. Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зохих өөрчлөлт оруулан ашиглаарай. Хавсралт **4.1.1 ба 4.1.2-ийг** ашиглаарай.

Алхам 2. Асуулгын үр дүнг нэгтгэн шинжилнэ.

Хувийн жинг тооцох. Тухайн хариултыг сонгосон хүний тоог судалгаанд оролцсон нийт хүнд хуваан, 100-аар үржүүлнэ. Хувийн жинг эрэгтэй, эмэгтэй оролцогчоор ангилан тооцож харьцуулаарай. Ингэхдээ тухайн хариултыг сонгосон эмэгтэйн тоог нийт эмэгтэйн тоонд хуваан, 100-аар үржүүлэн тооцно. Энэ аргачлалаар эрэгтэйчүүдийн хувийн жинг тооцож, хүйсээр харьцуулан дүгнэлт гаргана.

Алхам 3. Гол үр дүнг дүн шинжилгээний таван гол хүрээгээр нэгтгэн танилцуулна. Мөн дараах асуултыг танилцуулгад заавал харгалзаарай.

- * Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд ямар ялгаа илэрсэн бэ? Яагаад ийм байгаа вэ?
- * Асуулгаас аль асуултыг гүнзгийрүүлэн судалж, хэлэлцэх шаардлагатай гэж үзэж байна вэ?

ТАВ. ДҮГНЭХ, ТАЙЛАГНАХ НЬ

Дүгнэх, тайлагнах үе шат дараах 3 алхмын дагуу хэрэгжинэ.



Алхам 5.1 Тайлан бэлтгэх

Тайлан нь ОСЖА-ын гол үр дүн юм. ОСЖА-ын гол үр дүнг багтаасан, сайн туршлагыг онцолж, гүйцэтгэлийг сайжруулах зөвлөмжийг санал болгодог. ОСЖА-ын дүн шинжилгээний 5 гол хүрээнд хийсэн аудитын үр дүнг танилцуулж, дүгнэлтэд үндэслэсэн МБТБСБ-ын жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж байна.

1. ОСЖА-ын бичмэл тайланг арга зүй, үр дүн, дүгнэлт, зөвлөмж гэсэн үндсэн бүтэцтэйгээр боловсруулна. ОСЖА-ын тайлангийн нарийвчилсан агуулгыг Хавсралт 5.1-ын дагуу боловсруулж 5-10 хүртэлх нүүрэнд багтаан бичнэ.
2. Тайланд ашигласан хэл нь энгийн бөгөөд бүх ажилтанд ойлгомжтой байх ба хүйсээр ялгаварласан үг хэллэгээс зайлсхийнэ.
3. Тайлангийн үр дүнг бичихдээ баримтаар нотлогдсон нөхцөл байдлыг товч тодорхой томъёолж тайлбарлахаас гадна байгууллагын хүрээнд хэрэгжиж буй сайн туршлагыг онцлох шаардлагатай.

Алхам 5.2 Байгууллагын захирал болон нийт ажилтанд ОСЖА-ын үр дүн, дүгнэлтийг танилцуулах, санал авах

Жендэрийн аудитын тайлан бичсэний дараа үр дүнг МБТБСБ-ын захирал болон удирдах түвшний ажилтнуудад PowerPoint илтгэл бэлдэж танилцуулна.

1. ОСЖА-ын чиглүүлэгчдийн баг МБТБСБ-ын захирал болон удирдах түвшний ажилтнуудад мэдээлэл хийх уулзалтыг зохион байгуулж аудитын үр дүнг танилцуулна.
2. МБТБСБ-ын нийт ажилтанд жендэрийн аудитын үр дүн, зөвлөмжийг танилцуулах уулзалтыг зохион байгуулж, хэлэлцүүлнэ. Уулзалтад аудитын багийн бүх чиглүүлэгч оролцохоос гадна МБТБСБ-ын захирлыг урина.
3. ОСЖА-ын үр дүнг танилцуулахдаа “буруу”, “муу”, “дутагдалтай” зэрэг үг хэллэг ашиглахаас зайлсхийнэ. Үр дүн танилцуулах уулзалт хоёр цаг орчим үргэлжилнэ.
4. Дүн шинжилгээний таван гол хүрээ бүрээр хамгийн ихдээ гурваас таван ололт, сайн туршлагыг, мөн сайжруулахад чиглэсэн санал зөвлөмжийг танилцуулна. Санал зөвлөмж нь МБТБСБ-д хэр ач холбогдолтой, сайжруулах боломж, чадвар хэр байгааг харгалзах хэрэгтэй.

Зөвлөмжид ажилтнуудын саналыг авч нэгтгэнэ. Ингэхдээ оролцогчдыг дүн шинжилгээний таван хүрээ бүрээр хэлэлцэх багуудад хуваан ажиллуулж, саналыг нэгтгэнэ. Дараах 3 асуултын хүрээнд ажиллана. Үүнд:

1. МБТБСБ-ын жендэрийн төлөв байдал ямар байна вэ?
2. Ямар өөрчлөлт шаардлагатай байна вэ?
3. Өөрчлөлт хийх шаардлагатай асуудлуудаас алийг нэн тэргүүнд шийдэх шаардлагатай вэ?
4. Өөрчлөлтийг хийхэд та бүхний зүгээс ямар хувь нэмэр оруулах вэ?

Баг бүр дасгал ажлын үр дүнг танилцуулсны дараагаар том бүлгээр хэлэлцүүлж, нэн тэргүүнд хийх өөрчлөлтүүдийн хүрээнд саналыг нэгтгэнэ. Хавсралт 5.2-ыг **ашиглан нэгтгээрэй**.

17

Алхам 5.3 Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах

ОСЖА-ын үр дүн, зөвлөмжид тулгуурлан МБТБСБ-ын жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах нь жендэрийн аудитын үйл явцын үргэлжлэл гэж ойлгох шаардлагатай.

1. Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (ЖҮАТ) боловсруулахдаа ОСЖА-ын зөвлөмж болон үр дүнг танилцуулах уулзалтын үр дүнд тулгуурлана.
2. ЖҮАТ-г батлах, төсөв хуваарилах, хэрэгжүүлэхэд удирдлагын манлайлал, дэмжлэг чухал. ЖҮАТ-г боловсруулах шатанд удирдлагыг заавал оролцуулах шаардлагатай.
3. Хавсралт 5.2-ийг ашиглан ЖҮАТ-г боловсруулна.
4. Жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг МБТБСБ-ын нийт ажилтанд танилцуулна.
5. Жендэрийн үйл ажиллагааг төлөвлөгөөг дараах зурагт үзүүлсэн мөчлөгийн дагуу жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тасралтгүй хэрэгжүүлэхэд анхаарна.

* Гурван жил тутам жендэрийн аудит хийнэ¹.

* Хяналт шинжилгээг (мониторинг) жилд нэг удаа хийнэ². ХШ-г хийхдээ баримт бичгийн шинжилгээ, ярилцлага, асуулгын аргыг ашиглаж хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулж явц, өөрчлөлтөө хянана. (Хавсралт 5.3 ашиглаарай).

¹ Монгол Улсын Аудитын хууль, 18.1.4 зүйл

² Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, 6.1.1 зүйл

Хавсралт 1.1. Жендэр аудитын зорилго, зорилтууд

Жендэрийн аудитын зорилго нь МБТБСБ-д Олон улсын хөдөлмөрийн байгууллага (цаашид ОУХБ гэх)-ын оролцоонд суурилсан жендэрийн аудитын арга зүйгээр жендэрийн нөхцөл байдлыг тодорхойлох, байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлогын жендэрийн нөлөөллийг үнэлж байгууллагын хэмжээнд баримтлах жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Зорилтууд:

1. Байгууллагын жендэрийн бодлого, бүтцийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох
2. Байгууллагын баримт бичигт дүн шинжилгээ хийж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар холбогдох зохицуулалтыг тусгасан эсэхэд дүгнэлт өгөх,
3. Байгууллагын удирдлага, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын одоогийн нөхцөл байдлыг оролцоонд суурилсан жендэрийн аудитын аргачлалд тулгуурлан судлах, ажилтны жендэрийн мэдлэг, хандлагыг тодорхойлох,
4. Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан болон бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцогчдын хүйсийн харьцаа, төлөөлөл, оролцогч талуудын жендэрийн мэдлэг, хандлагыг илрүүлэх,
5. Байгууллагын мэдээллийн менежмент, ХШҮ-ний тогтолцоо нээлттэй, ил тод, ажилтан нэг бүрийн оролцоог хангаж буй эсэхийг тодорхойлох,
6. Жендэрийн аудитын үр дүнд тулгуурлан байгууллагын жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх, бодлогын тодорхой зөвлөмж боловсруулах,

Хавсралт 2.1 ОСЖА-ын календарчилсан төлөвлөгөө, сар, өдрөөр

Үе шат	Үйл ажиллагаа	Сар																																
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31		
Бэлтгэл үе шат	Зохицуулагчийг МБТБСБ-ын захирлыг тушаалаар томилох																																	
	Чиглүүлэгчдийн багийн бүрдүүлж, ажил үүргийг хуваарилах																																	
	Чиглүүлэгчдийн баг ОСЖА хийх төв, төлөвлөгөөг боловсруулах																																	
	МБТБСБ-ын удирдлагатай уулзаж, ОСЖА хийх хуваарь төлөвлөгөөг танилцуулах																																	
	Баримт бичгийн шинжилгээ болон стандартчилсан ярилцлагын удирдамж, асуулга боловсруулж эцэслэх																																	
	Баримт бичиг, материалуудыг бүрдүүлж, авах																																	
	Баримт бичгийн дүн шинжилгээ хийх, тайлангийн агуулга гаргах																																	
